



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/101/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Дорноговь аймаг Сайншанд сум  
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа  
Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn  
Аудитын менежерийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг  
Утас: 70523020 Цахим хаяг: injig78@yahoo.com  
Аудитор: Ц.Энхтуяа  
Утас: 99042645 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан .....	5
2.1.	Оршил .....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13.	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.2	БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүү байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dormogovi@audit.gov.mn	<b>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.ТУЯАЦЭЦЭГ ТАНАА</b>
2020.02.28 № 1-6/180 танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Туяацэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 01-нийн өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 03 -ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс аудит ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төв нь Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн эмчилгээ оношлогооны стандартыг хангаж, чанартай үйлчилгээ явуулахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн газар эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 44 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 293,426.8 мянган төгрөгөөс тооцон 5,868.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,349.8 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	966.5	248.5	(718.0)
Бараа материал	15,689.1	37,834.9	22,145.8
Үндсэн хөрөнгө	236,566.4	239,488.4	2,922.0
Нийт хөрөнгө	253,222.1	277,571.9	24,349.8
Өр төлбөр	646.6	-	(646.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	252,575.5	277,571.9	24,996.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	253,222.1	277,571.9	24,349.8

Ажилчидтай холбоотой 143.5 мянган төгрөгийн авлага, бусад зардлын 572.3 мянган төгрөгийн тооцооны авлага, албан томилолтын авлага 2.2 мянган төгрөгийн авлага тус тус төлөгдөж нийт 718.0 мянган төгрөгөөр буурсан байна. Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь эм боох материал 27,236.3 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 2,803.3 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 5,707.0 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 1,926.7 мянган төгрөгөөр, түлш шатахуун 28,620.8 мянган төгрөгөөр, хүнсний материал 2,990.3 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 2,328.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж нийт 49,467.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас 22,145.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бүх нэр төрлийн бараа материал бүрэн ашиглагдаж буюу ашиглагдаж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 27,642.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр бэлтгэж, 3,693.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталснаас шалтгаалан үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өглөг данс ажилчидтай холбоотой 595.8 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний 50.8 мянган төгрөгийн өр төлбөр тус тус төлөгдсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үндсэн хөрөнгө шинээр бэлтгэсэн, хуримтлагдсан үр дүнгээс хамаарч 24,996.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд нийт 301,863.9 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 293,426.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 97.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	275,158.1	275,156.1	(2.0)	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,800.0	10,802.0	2.0	100.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,905.8	7,468.7	(8,437.1)	47.0
<b>Нийт дүн</b>	<b>301,863.9</b>	<b>293,426.8</b>	<b>(8,437.1)</b>	<b>97.2</b>

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилт 8,437.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн нь эмнэлгээр үйлчлүүлэгчдийн тоо төлөвлөгөөнд хүрээгүй төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын төлөвлөгөөг бодиттой үнэн зөв төлөвлөдөггүй алдаа байна.

Урсгал зардлыг хэмнэсэн нь хангамжийн материалын зардлыг 8,773.4 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 1,598.3 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 312.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 61.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласнаас шалтгаалжээ.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 264.8 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

Үүнээс урсгал засварын зардалд 0.3 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 149.1 мянган төгрөг, аудит, баталгаажуулалтын зардалд 55.7 мянган төгрөг, тус тус зарцуулж 59.7 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг хийсэн байна.

#### **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 50.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг төлбөрийн акт тогтоолоо. Үүнд

Тус байгууллага 2019 оны амралтыг тооцон олгохдоо амралтын олговрыг илүү тооцон нийт 50703.5 төгрөгийг олгосон байна. Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

#### **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

##### 3.1.1 Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант хугацаанд 248.5 мянган төгрөгийн авлага, үлдэгдэл тайлагнасан байна. Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Төсвийн тухай хуулийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчсөн байна.

##### 3.1.2 Эрсдэл:

Авлагыг барагдуулаагүй байх, холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

##### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах;

##### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ

##### 3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалуудыг дансны ангилал зөрүүлж бүртгэсэн байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Дансны ангилал буруу бүртгэгдэх,

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.16 *“Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө.”* заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,655,648.70</b>	<b>38,083,411.33</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	966,511.10	248,462.29
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	143,517.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	822,994.10	248,462.29
3351	Байгууллагаас авах авлага	822,994.10	248,462.29
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	15,689,137.60	37,834,949.04
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,243,520.68	16,106,865.21
35110	Тусгай зориулалттай материал	112,496.06	112,496.06
35130	Эм боох материал	3,131,024.62	15,994,369.15
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,445,616.92	21,728,083.83
35410	Бичиг хэргийн материал	1,220,645.00	2,104,548.00
35420	Аж ахуйн материал	3,052,132.00	5,773,670.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,645,000.00	1,445,600.00
35440	Түлш, шатах тослох материал	3,479,982.45	9,443,150.00
35460	Хүнсний материал	1,051,387.47	1,258,245.83
35470	Бусад хангамжийн материал	1,996,470.00	1,702,870.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>236,566,420.92</b>	<b>239,488,445.72</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	236,566,420.92	239,488,445.72
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	229,330,420.92	232,252,445.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	197,687,929.76	197,687,929.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(5,792,437.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,443,990.00	38,443,990.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,079,789.42)	(37,518,995.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,653,846.26	111,120,587.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,359,788.59)	(85,446,233.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,321,530.73	25,404,559.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,724,797.56)	(14,534,454.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,500,000.00	6,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,112,500.26)	(4,012,500.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,236,000.00	7,236,000.00
39301	Програм хангамж	675,000.00	675,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(675,000.00)	(675,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,236,000.00	7,236,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>253,222,069.62</b>	<b>277,571,857.05</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>646,617.14</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	646,617.14	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	646,617.14	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	595,818.14	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	50,799.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>252,575,452.48</b>	<b>277,571,857.05</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	252,575,452.48	277,571,857.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,158,414.55	224,158,414.55
51101	Өмч: - төрийн	224,158,414.55	224,158,414.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(987,912.01)	24,008,492.56
51210	Өмнөх үеийн үр дүн	(987,912.01)	(987,912.01)
51220	Тайлант үеийн үр дүн	-	24,996,404.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,404,949.94	29,404,949.94
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>253,222,069.62</b>	<b>277,571,857.05</b>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>235,007,157.01</b>	<b>309,321,626.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,420,957.01</b>	<b>15,629,986.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,420,957.01	15,629,986.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,420,957.01	15,629,986.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,420,957.01	15,629,986.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>231,586,200.00</b>	<b>18,535,540.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	230,776,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	230,776,200.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	275,156,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	264,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	264,800.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	10,802,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	10,802,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	810,000.00	7,468,740.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	810,000.00	7,468,740.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>251,308,814.65</b>	<b>284,325,221.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>251,308,814.65</b>	<b>284,325,221.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	251,308,814.65	283,558,977.59
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	149,877,903.00	169,357,273.00
210101	Үндсэн цалин	141,558,303.00	130,853,980.00
210102	Нэмэгдэл	-	28,700,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,007,001.00
210104	Урамшуулал	8,319,600.00	6,796,292.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,270,428.59	21,199,843.67
210201	Тэтгэврийн даатгал	12,216,414.26	13,939,695.86
210202	Тэтгэмжийн даатгал	1,377,145.00	1,963,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,101,716.00	1,570,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	275,429.00	332,894.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,299,724.33	3,393,453.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,898,751.00	7,705,202.36
210301	Гэрэл, цахилгаан	984,251.00	997,573.30
210302	Түлш, халаалт	8,914,500.00	6,155,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	552,629.06
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,936,676.55	23,285,726.45
210401	Бичиг хэрэг	1,647,970.00	2,510,722.00
210402	Тээвэр, шатахуун	16,196,998.55	16,678,372.45
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	59,999.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,780,994.00	2,970,432.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	250,715.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	646,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,117,253.49	19,068,796.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,780,267.83	15,228,505.27
210502	Хоол, хүнс	3,336,985.66	3,840,291.64
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,530,400.00	2,129,100.00
210604	Урсгал засвар	1,530,400.00	2,129,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,575,900.00	1,504,500.00
210702	Дотоод албан томилолт	1,575,900.00	1,504,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,661,933.00	12,703,985.00

**Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,227,881.00	12,386,711.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	280,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	65,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,010.00	46,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	28,592.00	23,404.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,439,569.02</b>	<b>26,604,550.20</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,070,666.00	1,883,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,368,903.02	24,720,750.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	766,243.84
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	766,243.84
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(16,301,657.64)</b>	<b>24,996,404.57</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	66,648.52	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	66,648.52	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(66,648.52)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(16,368,306.16)</b>	<b>24,996,404.57</b>

**4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>231,586,200.00</b>	<b>293,691,640.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>231,586,200.00</b>	<b>293,691,640.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	230,776,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	230,776,200.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	275,156,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	264,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	264,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	10,802,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	10,802,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	810,000.00	7,468,740.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	810,000.00	7,468,740.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>231,586,200.00</b>	<b>281,132,940.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>231,586,200.00</b>	<b>281,132,940.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>231,451,613.63</b>	<b>280,366,696.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	144,168,499.19	168,897,156.00
210101	Үндсэн цалин	135,989,399.19	130,393,863.00
210102	Нэмэгдэл	-	28,700,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,007,001.00
210104	Урамшуулал	8,179,100.00	6,796,292.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,946,000.00	21,539,500.00
210201	Тэтгэврийн даатгал	12,014,000.00	13,686,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,483,000.00	1,963,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,186,400.00	1,570,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	296,600.00	392,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,966,000.00	3,926,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,202,212.00	9,000,202.36
210301	Гэрэл, цахилгаан	1,002,212.00	1,118,202.36
210302	Түлш, халаалт	7,200,000.00	7,450,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	432,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,515,500.00	27,461,565.00

**Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	1,049,500.00	2,378,325.00
210402	Тээвэр, шатахуун	14,205,700.00	21,046,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	59,999.00	88,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	636,681.00	1,355,970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	563,620.00	2,592,970.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,148,325.44</b>	<b>31,592,087.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,379,975.44	27,048,198.80
210502	Хоол, хүнс	2,518,350.00	2,999,889.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,000.00	1,544,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,109,600.00</b>	<b>2,769,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,860,000.00	863,000.00
210604	Урсгал засвар	2,249,600.00	1,906,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,578,100.00</b>	<b>1,502,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,578,100.00	1,502,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,783,533.00</b>	<b>12,703,985.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,469,481.00	12,386,711.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	65,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,010.00	46,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	28,592.00	23,404.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,999,844.00</b>	<b>4,900,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,999,844.00	4,900,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>134,586.37</b>	<b>766,243.84</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>134,586.37</b>	<b>766,243.84</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	=	<b><u>12,558,700.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>12,558,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>12,558,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>12,558,700.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	12,558,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b><u>(12,558,700.00)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,922,414.55	148,444,186.57	54,171,095.15	419,537,696.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	216,922,414.55	148,444,186.57	54,171,095.15	419,537,696.27
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,684,917.56)	(14,684,917.56)
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,158,414.55	29,404,949.94	(987,912.01)	252,575,452.48

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,158,414.55	29,404,949.94	(987,912.01)	252,575,452.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	224,158,414.55	29,404,949.94	(987,912.01)	252,575,452.48
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	24,996,404.57	24,996,404.57
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,158,414.55	29,404,949.94	24,008,492.56	277,571,857.05

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	301,863,900.0	293,426,840.0	(8,437,060.0)	97.2
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	301,863,900.0	293,426,840.0	(8,437,060.0)	97.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	301,863,900.0	292,720,296.2	(9,143,603.8)	97.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	169,520,000.0	168,897,156.0	(622,844.0)	99.6
210101	Үндсэн цалин	130,400,000.0	130,393,863.0	(6,137.0)	100.0
210102	Нэмэгдэл	28,700,000.0	28,700,000.0	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,620,000.0	3,007,001.0	(612,999.0)	83.1
210104	Урамшуулал	6,800,000.0	6,796,292.0	(3,708.0)	99.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,539,500.0	21,539,500.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	13,686,700.0	13,686,700.0	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,963,200.0	1,963,200.0	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,570,600.0	1,570,600.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	392,600.0	392,600.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,926,400.0	3,926,400.0	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,052,000.0	9,000,202.4	(51,797.6)	99.4
210301	Гэрэл, цахилгаан	1,120,000.0	1,118,202.4	(1,797.6)	99.8
210302	Түлш, халаалт	7,500,000.0	7,450,000.0	(50,000.0)	99.3
210303	Цэвэр, бохир ус	432,000.0	432,000.0	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,468,800.0	27,549,565.0	(5,919,235.0)	82.3
210401	Бичиг хэрэг	2,402,000.0	2,378,325.0	(23,675.0)	99.0
210402	Тээвэр, шатахуун	25,311,700.0	21,046,300.0	(4,265,400.0)	83.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	417,100.0	88,000.0	(329,100.0)	21.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,700,000.0	1,399,970.0	(300,030.0)	82.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,638,000.0	2,636,970.0	(1,001,030.0)	72.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33,698,800.0	31,742,087.8	(1,956,712.2)	94.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,198,800.0	27,198,198.8	(601.2)	100.0
210502	Хоол, хүнс	4,500,000.0	2,999,889.0	(1,500,111.0)	66.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	1,544,000.0	(456,000.0)	77.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,750,000.0	13,714,000.0	(36,000.0)	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.0	5,364,000.0	(136,000.0)	97.5
210602	Тавилга	6,500,000.0	6,500,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,750,000.0	1,850,000.0	100,000.0	105.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,500,000.0	1,353,200.0	(146,800.0)	90.2
210702	Дотоод албан томилолт	1,500,000.0	1,353,200.0	(146,800.0)	90.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,098,600.0	12,703,985.0	(394,615.0)	97.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,730,400.0	12,386,711.0	(343,689.0)	97.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.0	160,000.0	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.0	65,340.0	(34,660.0)	65.3

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,200.0	46,530.0	(4,670.0)	90.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	22,000.0	-	100.0
210807	Газрын төлбөр	35,000.0	23,404.0	(11,596.0)	66.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,236,200.0</b>	<b>6,220,600.0</b>	<b>(15,600.0)</b>	<b>99.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,236,200.0	6,220,600.0	(15,600.0)	99.7
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>301,863,900.0</b>	<b>293,426,840.0</b>	<b>(8,437,060.0)</b>	<b>97.2</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>275,158,100.0</b>	<b>275,156,100.0</b>	<b>(2,000.0)</b>	<b>100.0</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	275,158,100.0	275,156,100.0	(2,000.0)	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>10,800,000.0</b>	<b>10,802,000.0</b>	<b>2,000.0</b>	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	10,800,000.0	10,802,000.0	2,000.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>15,905,800.0</b>	<b>7,468,740.0</b>	<b>(8,437,060.0)</b>	<b>47.0</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,905,800.0	7,468,740.0	(8,437,060.0)	47.0

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>264,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>264,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	205,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	307.00
210604	Урсгал засвар	307.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	149,100.00
210702	Дотоод албан томилолт	149,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	55,693.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	55,693.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>59,700.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	264,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	264,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	264,800.00